



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2020.09.03 № СНА-2020/06-НА-69
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Буянгийн Наранбаярын мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Б.Наранбаяр нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050" холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

018020859


Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Б.Наранбаярын Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Б.Наранбаярын мөрийн хөтөлбөр /.....² хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Хүдэр сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮДЭР СУМЫН 2020 ОНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ БУЯН ОВОГТОЙ НАРАНБАЯРЫН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



Нэг. Ард иргэдийг мэдлэг боловсролтой, ёс зүйтэй, аз жаргал дүүрэн амьдрах боломжийг бий болгох зорилтын хүрээнд:

- 1.1. Боловсролын салбарыг бүх түвшинд харилцан уялдаатай хөгжүүлэх бодлогыг дэмжиж, хууль, эрх зүйн баримт бичигт тусгасан ажлыг хэрэгжүүлнэ.
- 1.2. Хүдэр сумын өвөрмөц хөгжилд тулгуурласан хүний хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.
- 1.3. Сургуулийн өмнөх боловсрол болон бага боловсролын агуулгад үндэсний уламжлалт өв соёлыг тусгах замаар Монгол хүний сэтгэхүйн давхрааг бий болгох ажлыг дэмжинэ.
- 1.4. Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв болон дээд боловсрол эзэмших гэж буй суралцагчдын мэргэжил сонголтод тусалж ажиллана.
- 1.5. Боловсролын ололт амжилтыг үйлдвэрлэл болон бизнест нэвтрүүлэх нөхцөл бололцоог хангах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.
- 1.6. Суманд амьдарч байгаа залуу болон олон хүүхэдтэй гэр бүлийг төсөл хөтөлбөрт хамруулах ажлыг холбогдох байгууллагад уламжлан, амьжиргааг дээшлүүлэхэд дэмжиж ажиллана.
- 1.7. Багш, эмчийн ажлын үнэлэмжийг дээшлүүлэх цогц бодлого болон гарсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.
- 1.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн үйл хэрэгт идэвхтэй оролцуулах үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- 1.9. Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, тэтгэвэр тэтгэмжийн хуулийн хэрэгжилтэд холбогдох байгууллагатай хамтран хяналт тавьж ажиллана.
- 1.10. Малчид, тариаланчдын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр явуулж байгаа насан туршийн боловсролын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

Хоёр . Ард иргэдийг ажилтай орлоготой эдийн засгийн чадавхтай болгох нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

- 2.1. Баялгийн хуримтлал хуваарилалтыг тэгш шударга болгох чиглэлээр бодлогын болон хууль эрх зүйн баримт бичгийг боловсронгуй асуудлыг холбогдох байгууллагад уламжилна.
- 2.2. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний зах зээлийг өргөжүүлэх бодлогыг дэмжинэ.
- 2.3. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон газар тариалангийн бодлогыг тууштай дэмжиж, газар тариаланг хөгжүүлэх хөтөлбөрийг холбогдох байгууллагатай хэрэгжүүлнэ.

- 2.4. Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнээр нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх , хадгалах , борлуулах чиглэлээр явуулж байгаа аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.

Гурав. Ард иргэдийг байгаль экологийн цэвэр эрүүл орчинд амьдрах ногоон хөгжлийг дэмжсэн бодлого хэрэгжүүлэх зорилтын хүрээнд

- 3.1. Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж буй аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллана.
- 3.2. Байгаль эх орноо хайрлах үндэсний өв уламжлалыг сэргээж, экологид ээлтэй амьдралын хэв маяг болох мод модон материалын үйлдвэрлэлийг, дэмжих ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 3.3. Бэлчээрийн газрын доройтол хөрсний элэгдэл, уул уурхайн зохисгүй ашиглалтыг бууруулах эко системийн тэнцвэрт байдлыг хадгалах, нөхөн сэргээлтийг дэмжих бодлогыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- 3.4. Ард иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай амьдрах суурь нөхцөлийг тодорхойлж сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.
- 3.5. Сумандаа цэвэр цэмцгэр орчинд амьдрах боломжийг бүрдүүлэх хөтөлбөр боловсруулан холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 3.6. Баталгаат ундны усаар хангагдах нөхцөл боломжийг судалж, хэрэгжүүлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.
- 3.7. Ойн санг гэрээгээр эзэмшиж буй ААН-үүдтэй ойжуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллана.

Мөрийн хөтөлбөр боловсруулсан :

Буян овогтой Наранбаяр

